

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-5

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан нарын 3 гишүүн 2023.10.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	3
2. Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай	4-5

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 10 дугаар сарын 12-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 24 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Доржханд, Б.Пүрэвдорж;
Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Ж.Батсуурь, М.Оюунчимэг, Л.Оюун-Эрдэнэ,
Д.Сарангэрэл.

Нэг.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан нарын 3 гишүүн 2023.10.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, мөн хорооны Хуулийн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Г.Анар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референтийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Наранцэцэг, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга Н.Энхболд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Н.Энхболд: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн саналыг дэмжсэнээр тооцож, 80.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан 13 цаг 28 минутаас 17 цаг 01 минут хуртэл түр завсарлав.

Хоёр.Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, ахлах референт Г.Анар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референтийн үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Наранцэцэг, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд Улсын Их Хурлын гишүүн Хишгээгийн Нямбаатарын Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Хишгээгийн Нямбаатарын Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Н.Энхболд “Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 08 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 17 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжсин Д.Сүхбаатар”
танхим,
13 цаг 24 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн мэнд хүргэе.

Ирц хүрсэн байна. Ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн ирсэн байна. Ингээд Төрийн байгуулалтын байнгын хорооны ирц хүрсэн тул 2023 оны 10 сарын 05-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. 12-ны өдрийн хуралдаан.

Одоо хэлэлцэх асуудал танилцуулъя.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна.

Ажлын хэсэг оруулчихъя.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, ажлын албаны дарга Баяндүүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны Хуулийн хэлтсийн дарга Бат-эрдэнэ нар оролцож байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж асуух гишүүн байна уу. Байхгүй байна.

Хуулийн төслөө зүйл бүрээр хэлэлцэнэ.

1 зүйлтэй хуулийн төсөл байгаа.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Зүйл бүрээр хэлэлцэж дууссан учраас уг хуулийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Зарчмын зөрүүтэй горимын санал гаргая.

Дэгийн тухай хуулийн 39.22-т хуулийг хэлэлцэх явцад зарчмын зөрүүтэй санал гараагүй бол анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэж явуулах горимын санал гаргаж болно гэсэн ийм заалт байгаа. Ийм горимын санал гаргаж байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр нь эцэслэн батлах үе шаттай нь нэгтгэж явуулъя гэсэн горимын саналыг дэмжиж байгаа гишүүд саналаа өгье. Санал хураалт. Гишүүдээ, санал аа. Амараа гишүүн ээ.

Хуралдаанд оролцсон 10 гишүүнээс 7 нь дэмжиж, 70 хувиар уг санал дэмжигдлээ.

Мөнхцэцэг гишүүнийг дэмжсэнээр протоколд тусгаж яваарай.

13.28 цаг

Үүгээр хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан түр завсарлаж байна. Бид нар үдээс хойш бас хотын хурлын явцтай

холбогдуулаад асуудал орж ирэх ёстой. Тийм учраас ирц үүгээрээ байж байгаад үдээс хойш үргэлжлүүлээд хуралдана.

Хаагаагүй шүү, тийм.

Анхны хэлэлцүүлгийн тухай санал, дүгнэлтийг би өөрөө танилцуулчихъя даа, чуулганы нэгдсэн хуралдаанд.

Хуралдаан түр завсарлалаа. Гишүүддээ баярлалаа.

Ирц үүгээрээ байх юм шүү. Техникийн албаныхан энэ ирцийг хадгалж байгаарай.

Баярлалаа, гишүүддээ.

ҮДЭЭС ХОЙШИХ ХУРАЛДААНЫ ҮРГЭЛЖЛЭЛ

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүдийг хуралдааны танхимд ирэхийг урьж байна.

Хуралдаан үргэлжлэх гэж байна. Төрийн байгуулалтын байнгын хорооны.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн байна.

Тийм учраас 2023 оны 10 сарын 12-ны өдрийн хуралдаанаа үргэлжлүүлье. Ирц өглөөнийхөөр явж байгаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх асуудал байгаа, тухай асуудал хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг дуусгавар болгох үндэслэлүүдийг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд

заасан байгаа. 10.1.2-т хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөөлөх хүсэлтээ өөрөө гаргасныг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол уг гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болно гэж заасан. Үүний дагуу Монгол Улсын Их Хурлын гишүүн Хишигээгийн Нямбаатар Монгол Улсын Их Хурлын даргад хүсэлтээ ирүүлсэн байгаа.

Хүсэлтийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Хишигээгийн Нямбаатар миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтыг үндэслэн, энэ заалт нь бол хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөөлөх хүсэлтээ өөрөө гаргасныг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болно гэсэн ийм заалт байгаа. 10.1.2 нь. Энэ заалтыг үндэслэн энэхүү хүсэлтийг гаргаж байгаа бөгөөд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан журмын дагуу Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас намайг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид нэр дэвшүүлснийг миний бие хүлээн авсантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхээсээ татгалзаж, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаж байна.

Надад өндөр итгэл хүлээлгэж, Улсын Их хурлын гишүүнээр 2 удаа сонгож, намайг дэмжиж, эрч хүч, урам зориг өгсөөр ирсэн Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн иргэд, сонгогчдодоо чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлье. Хүндэтгэсэн Улсын Их Хурлын гишүүн Нямбаатар гэсэн ийм хүсэлт ирсэн.

Гишүүний хүсэлттэй холбогдуулаад асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй байна.

Үг хэлэх гишүүн байна уу. Байхгүй байна.

Санал хураана. Одоо Улсын Их Хурлын гишүүн Хишгээгийн Нямбаатарын Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Хуралдаанд 11 гишүүн оролцож санал өгч, 7 гишүүн дэмжиж, 63,6 хувиар гишүүний хүсэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж Байнгын хороо үзлээ.

Би Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулъя. Их Хурлын тогтоолын төсөл.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт, 10.2, 10.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Хишгээгийн Нямбаатарыг өөрийнх нь хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлсүгэй.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна. Үүнийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оруулна. Дүгнэлтийг би өөрөө уншаад танилцуулчихъя.

Байнгын хороогоор хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

17.05 цаг

Гишүүддээ баярлалаа.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

П.ОЮУНГЭРЭЛ